

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 07 дугаар сарын 07

Дугаар 76

Улаанбаатар хот

Бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.5 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, 27 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 189 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Баянзүрх дүүргийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулж ажиллахыг зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ч.Мэндсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07  
дугаар сарын .....-ны өдрийн арван  
гуравдугаар хуралдааны .... дугаар  
тогтоолын хавсралт

Баянзүрх дүүргийн Гамшгийн эрсдэлийг бууруулах  
орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Зөвлөлийн орлогч дарга	Онцгой байдлын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга
Гишүүд	Засаг даргын орлогч Засаг даргын Тамгын газрын дарга Дүүргийн Цагдаагийн газрын дарга Дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Дүүргийн Газар зохион байгуулалтын I, II албаны дарга Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Дүүргийн Улаан загалмайн хорооны дарга Шинжлэх Ухааны Академи, Газарзүй Геоэкологийн хүрээлэнгийн Цэвдэг судлалын салбарын эрхлэгч, доктор Шинжлэх Ухааны Академи, Газарзүй Геоэкологийн хүрээлэнгийн Усны нөөц, ус ашиглалтын салбарын дарга, доктор Имарт худалдааны төвийн захирал Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагын “Баянзүрх дүүргийн хөтөлбөр”-ийн менежер (тус тус зөвшилцсөнөөр)
Нарийн бичгийн дарга	Онцгой байдлын хэлтсийн Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн